



БОЛОВСРОЛ,
СОЁЛ,
ШИНЖЛЭХ УХААНЫ ЯАМ



Дээд Боловсролын Шинэчлэлийн Төсөл

АХБ-ны Төслийн дугаар: 43007-023

Төслийн код: HERP MON Зээлийн дугаар: 2766

Дээд Боловсролын Шинэчлэлийн Олон Улсын Зөвлөх Үйлчилгээ

**Сургалтын хөтөлбөр, сургах, сурах үйл ажиллагааны
зөвлөхүүдийн боловсруулсан бүтээгдэхүүн**

**ДБСБ-УУДЫН ХӨТӨЛБӨРИЙН ИНТЕГРАЦЧИЛАЛ ҮЙЛ ЯВЦАД ҮЗҮҮЛЭХ
ЗӨВЛӨМЖ**

Сургалтын хөтөлбөр, сургах, сурах үйл ажиллагааны баг

Dr. Jean-Guy Vienneau

Олон улсын зөвлөх

Dr. А.Амарзаяа

Үндэсний зөвлөх



Улаанбаатар хот

2017 он



PT.TRANS INTRA ASIA

HERP PROJECT
CURRICULUM, TEACHING AND LEARNING COMPONENT
LIBERAL ARTS CURRICULUM AND COMPETENCIES ACQUISITION
PRESENTED BY
AMARZAYA AMARTURSHIN AND JEAN-GUY VIENNEAU
CONSULTANTS

УДИРТГАЛ

Либерал артын хичээл, хөтөлбөр нь оюутнуудад хичээлүүдийг холбож сэтгэх бас суралцах боломж олгон оюун санааг бүрэн дайчилж өгдөг. Энэхүү боловсролын үндэс суурь нь чи юу судлаж байгаа тухай биш үр дүн нь юм. Өөрөөр хэлбэл шүүмжит бөгөөд бие даан суралцах чадвар эзэмшиж, тодорхой, ойлгомжтойгоор бичиж, харилцаж, үндэслэл гараж суралцаж, бүх мэргэжлийн суурь болдог.

Энэхүү өгүүлэлд эхлээд бид либерал артын боловсролын утга санаа тэр дундаа хамгийн чухал нь боловсрол эзэмшиж байх хугацаандаа суралцагчийн эзэмших мэдлэг, чадварын талаар тайлбарлана.

Мөн курс-хичээлийн дизайнчлал, төлөвлөлтийн талаар шинэ үзэл, онолыг танилцуулна.

ЛИБЕРАЛ АРТЫН БОЛОВСРОЛ

Орчин үед либерал артын боловсрол гэж юу вэ? Энэхүү өргөн салбарт маш олон хичээл багтдаг ба ихэнх либерал артын хөтөлбөрүүд салбар хоорондынх байдаг ба хүмүүнлэг, нийгэм, байгалийн ухаан, формал шинжлэх ухааныг хичээлүүдийг хамардаг. Сургуулиудын либерал артын хөтөлбөрүүдэд ордог хичээлүүд ялгаа байдаг. Гэхдээ либерал артын хичээлүүд дараах хичээлүүдийг хамардаг:

- **Хүмүүнлэгийн ухаан** – дотроо урлаг, утга зохиол, хэл шинжлэл, философи, шашин, ёс зүй, гадаад хэл, хөгжим, театр, илтгэх урлаг, эртний сонгодог хэл (Латин/Грек) зэргийг агуулдаг.
- **Нийгмийн ухаан** – дотроо түүх, сэтгэл судлал, хууль, социологи, улс төр судлал, жендер судлал, антропологи, эдийн засаг, газарзүй, бизнесийн мэдээлэл зүй зэргийг агуулдаг.
- **Байгалийн ухаан** – дотроо одон орон, биологи, хими, физик, ботаник, археологи, амьтан судлал, геологи, дэлхий судлал зэргийг агуулдаг.
- **Формал шинжлэх ухаан** – дотроо математик, логик, статистик зэргийг агуулдаг.

“Либерал арт” гэдэг хэллэг нь дээрх мэргэжлүүдийн нэгийг нь сонгон авсан сургалтанд бас хамаардаг (жишээ нь, Философийн бакалаврийн оюутныг либерал артын оюутан гэж хэлдэг). Ерөнхийдөө энэхүү хэллэг нь өргөн хүрээний мэдлэг, үр чадвар олгох бакалаврын зэргийн хөтөлбөрт хамаарна.

Либерал артын боловсрол нь суралцагчыг шүүмжлэлтэйгээр сэтгэж, өөрийн орчин тойрныг шинжилж, үр дүнтэйгээр харилцан, өөрчлөгдөж буй нөхцөл нөхцөлд дасан зохицож

сурахад бэлтгэнэ. Хэрэв оюутан хууль, анагаах гэх мэт мэргэжлийн салбарт орохыг хүсвэл либерал артын хөтөлбөр нь тухайн оюутныг сургалтаа ахисан түвшинд үргэлжлүүлэхүйц байдлаар бэлтгэдэг.

Либерал артын боловсрол нь үндсэн шинж чанараараа нарийн, мэргэшсэн гэхээсээ илүүтэй өргөн, олон салаалсан байдаг. Олон салбараас хичээлүүд сонгох нь суралцагчид өргөн бөгөөд хэрэгтэй боловсролыг олгоно. Энэ нь салбаруудын өргөн мэдлэг олгох боловч цаашдын судалгааны тодорхой чиглэлийг сонгоход тусладаг. Үүний зэрэгцээ либерал артын хөтөлбөр нь ихэвчлэн тодорхой салбар эсвэл агуулгын хувьд холбоотой хичээлүүдийн бүлэгт буй мэргэжлийн хөтөлбөр эсвэл ийг эзэмших боломж олгодог. Өгсөн салбар дээр төвлөрснөөр өнгөн хэсгээс гүнд нэвтэрч тухайн салбарынхаа үндсэн материалын талаар гүн бат мэдлэгтэй болно.

ЛИБЕРАЛ АРТЫН БОЛОВСРОЛ ДАХЬ МЭДЛЭГ, ЧАДВАНУУД

Либерал артын хөтөлбөр, хичээлүүд нь оюутнуудыг орчин үеийн ертөнцөд ажиллагчдаас шаардаж буй үр чадваруудын багц буюу чадамжуудыг гүн бат эзэмшихэд бэлтгэдэг. Эдгээр үр чадваруудын олонх нь “soft үр чадвар” буюу ажилд ороход шаардлагатай үр чадвар гэж нэрлэгддэг орчин үеийн болон ирээдүй хойч үеийн ажиллагчдад шаардлагатай цогц чадамжууд юм.

Либерал артын боловсрол нь ажил олгогчид өндрөөр үнэлдэг бодитой, практик үр чадваруудыг олгоно. Мөн оюутан хэзээ ч хуучрахгүй мэдлэг, чадварыг олж авдаг. Дэлхий маш хурдан өөрчлөгдөж байгаа бөгөөд өөрийгөө тодорхой салбарт тохируулж хэт нарийвчлан бэлтгэвэл хөдөлмөрийн зах зээл дээр гарах үед тэр мэргэжил байхгүй болсон байх ч эрсдэлтэй. Харин либерал артын хөтөлбөрүүдээр олгож буй үр чадвар, чадамжууд нь үргэлж ач холбогдолтой байдаг.

Либерал арт хөтөлбөрт хамаарах гол үр чадварыг харцгаая:

- Аналитик болон мэдлэг бүтээх үр чадвар
- Аман, бичгэн болон МХТ-ийн үр чадвар, сонсох урлаг
- Синтез, үнэлэх ба шүүмжит сэтгэлгээ
- Шүүмжит бөгөөд тунгаан бодох үншлага
- Бүтээлч байдал
- Мэдлэг болон мэдээллийг удирдах
- Асуудал шийдвэрлэх
- Уншиж ойлгох чадвар
- Бусадтай хамтарч ажиллах, багаар ажиллах
- Ялгаатай байдал болон бусад соёлыг мэдэрч, хүлээн зөвшөөрөх
- Өөрийгөө, цаг хугацааг болон эрэмбүүдийг удирдах
- Өөрийгөө болон бусдыг манлайлан зоригжуулах
- Бие даан дүгнэлт өгч, ёс зүйтэй шийдвэр гаргах
- Нээлттэй байдал
- Бусдыг ойлгох
- Аналитик болон тоон үр чадвар
- Суралцаж сурах

ЛИБЕРАЛ АРТ БОЛОВСРОЛ ДАХЬ АРГА ЗҮЙ

Ихэнх их сургуулиуд либерал артын боловсрол олгодог бол зарим их сургуулиуд либерал артаар тусгайлан мэргэжил эзэмшүүлдэг. Ийм их сургуулиуд голчлон өөрийн хөрөнгө, нөөц, анхаарлыг либерал артын боловсрол олгоход анхаардаг бөгөөд сургалтын хэлбэр нь олон салбар, судлагдахуунуудыг хамарсан байдлаар оюутнуудыг сургадаг. Хойд америкт либерал артын боловсрол олгодог ихэнх их сургуулиуд ахисан түвшний оюутнууд, туслах багш(ТА), судалгааны профессор гэхээсээ илүү бүрэн ачааллаар багшилдаг багш олонтой байдаг. Либерал артын ихэнх коллежууд нь хэмжээгээр жижиг, оюутны тоо цөөн, багш-оюутны харьцаа бага, багш нар нь менторын үүрэгтэй бөгөөд оюутнуудынхаа судалгааны хамтрагч нь байдаг. Либерал арт боловсролын өөр нэг онцлог бол сургалт нь оюутны оролцоон дээр нилээн түшиглэж багш-оюутны өндөр хэмжээний харилцан ажиллагаа, ментор, хамтын ажиллагааг дэмжиж, урамшуулдаг.

Либерал артын боловсрол нь Европоос гаралтай, Хойд америкт тийм ч их давамгайл биш ч либерал артын зэргийн хөтөлбөрүүд улам бүр элбэг болж байгаа. Европын ихэнх улсууд бакалаврын түвшинд заах чиглэлээр мэргэшсэн либерал артын сургалтын байгууллагуудтай болж байгаа.

Курс –хичээлийн дизайнчлал

Багшлах үйл ажиллагаа нь цогц үйл ажиллагаа байдаг. Багшийн хийдэг олон үйл ажиллагааг дараах дөрвөн хэсэгт хувааж болно. Үүнд:

- Сэдвийн мэдлэг
- Олгох гэж буй мэдлэгийн зорилго, төлөвийн талаарх шийдэл
- Суралцагч, оюутантай харилцан ажиллах(лекц, семинар, хэлэлцүүлэг, уулзалт гэх мэт)
- Тухайн курс хичээлийн дизайнчлал болон менежмент зэрэг юм.

Эдгээрийг хэр зэрэг өндөр түвшинд шийдэж чадах нь оюутны сурлагын амжилтанд чухал нөлөөтэй. Их дээд сургуулиуд сэдвийн мэдлэгийг бакалаврын болон ахисан түвшинд өндөр түвшинд олгох зорилт тавьдаг. Мөн багшийн мэргэжил дээшлүүлэх болон тусгайлсан сургалтын хүрээнд оюутнуудтай харилцах харилцааны арга, техникүүдтэй танилцах боломжтой. Сургууль, тэнхмийн хөтөлбөрийн хороод дээр олгох гэж буй мэдлэгийн зорилго, төлөвийн талаарх шийдэл гарах боломжтой бол тухайн курс-хичээлийн дизайнчлал болон менежмент нь багшийн хариуцаж хийх ажил, үүрэг юм. Гэхдээ олон багшийн хувьд энэ ажил нь түвэгтэй, хүнд ажил байдаг.


Хичээлийн дизайнчлалын талаар бид Ди Финкийн (Fink, 2003) авч үзсэн онолын дагуу энд товчлон дурьдая.

Багш нар өөрийн заах курс-хичээлээ ихэвчлэн хоёр янзаар дизайнчилдаг. (Fink, 2003) Хамгийн түгээмэл тохиолддог дизайнчлалын арга нь “агуулгад суурилсан” арга буюу зарим тохиолдолд “сэдвүүдийн жагсаалт” гэж нэрлэдэгдэх багш ихэвчлэн өөрийн ойлголтод үндэслэн эсвэл нэг болон хэд хэдэн ном, сурах бичгээс чухал гэсэн сэдвүүдийг түүн авч тэдгээрт хэр их хугацаа зарцуулах, шалгалтын агуулгыг аль хэсэгт илүү их төвлөрүүлэх талаар шийдэл гаргадаг арга юм. Энэ аргын давуу тал нь нөгөө аргатай харьцуулбал харьцангуй хялбар, энгийн 30 минутаас 1 цагийн дотор дизайнчлалыг хийх боломжтой. Гэхдээ энэ арга нь зөвхөн суурь зарим мэдлэгийг олгоход л анхаарах бөгөөд судалгаануудаас харвал ийм курсээр олж авсан оюутны мэдлэг нь богино хугацаанд

мартагддаг. Хамгийн том сул тал нь энэ арга нь оюутны болон орчин үеийн нийгмийн эрэлт, хэрэгцээг огтоос тусгадаггүй.

Курс-хичээлийг дизайнчлах өөр нэг арга нь Ди Финк(Fink, 2003)-ийн боловсруулсан суралцахуйд төвлөрсөн, системчилсэн загвар юм. Энэ аргын хамгийн эхэнд, голлон анхаардаг асуудал нь оюутан энэхүү сэдвийн хүрээнд юуг, хэрхэн сурах вэ, түүнийг хэрхэн зохион байгуулж, хүргэх вэ гэдгийг шийдэх юм. Энэ арга нь хэдийгээр хугацаа, хүчин чармайлт шаардах хэдий ч оюутнуудад сурах боломжийг их хэмжээгээр олгож өгдөг давуу талтай.

Энэхүү загварыг курс-хичээлийн дизайнчлалын интеграцчилсан загвар гэж нэрлэдэг бөгөөд дараах загвартай байна.



Зураг 1

Хичээлээ дизайнчлахын тулд багш эхлээд нөхцөл байдлын хүчин зүйлүүдийг тодорхойлох шаардлагатай болно.

Эдгээрийг ашиглан

- Суралцагчид юу сураасай гэж би хүсэж байна вэ? (Суралцахуйн зорилго, зорилт)
- Эдгээр зорилгод хүрсэн эсэхийг багш болон оюутан хэрхэн мэдэх вэ? (Хариу мэдээлэл(Фийдбак) ба үнэлгээ)
- Зорилго, зорилтод хүрэхийн тулд багш, оюутнууд юу хийх вэ? (Багшлах, суралцах үйл ажиллагаа) зэргийг тодорхойлно.

Төгсгөлд нь эдгээр бүрэлдэхүүн хэсгүүдийг хооронд нь интеграцчилан бие биенээ дэмжихүйц болгоно. Дээрх алхмуудын талаар дэлгэрэнгүй тайлбарлая.

1-р алхам. Нөхцөл байдлын хүчин зүйлүүдийг тодорхойлох

Курс-хичээлийг дизайнчлах ажил нь нөхцөл байдлыг маш сайн тодорхойлохоос эхэлдэг. Энэ ажлын хүрээнд багшлах болон суралцах үйл ажиллагааны өнөөгийн нөхцөл байдлыг мөн шаардлагатай бол нэмэлт асуудлуудыг судлаж үздэг. Энэхүү судалгаа нь хичээлийг хэрхэн зохион байгуулах талаар шийдэл гаргахад чухал үндэслэл болж өгдөг. Хичээлийн дизайнд чухал нөлөө болдог дараах хүчин зүйлүүд байдаг. Үүнд:

1. Хичээл, сургалтын тусгай нөхцөл байдал. Хичээлийг хэдэн оюутан судлах вэ? Хичээл нь аль курсийн оюутнуудад зориулсан бэ? Хэр олон давтамжтайгаар оюутнуудтай уулзаж байх вэ? Хичээлийг дан нүүр тулсан байдлаар, онлайн, лаборатори гэх мэт ямар хэлбэрээр зохион байгуулах вэ? Хичээлд тоног төхөөрөмж, физик ямар хүчин зүйл шаардлагатай вэ?
2. Суралцахтай холбоотой ерөнхий асуудлууд. Сургууль болон мэргэжлийн хүрээлэл, нийгмээс хөтөлбөрийн талаар юуг хүсэн хүлээж байгаа вэ?
3. Мэргэжил, сэдвийн үүднээс. Курс-хичээлийн агуулга, сэдэв нь онолын үндсэн сэдэв үү, практикийн асуудал уу, эсвэл эдгээрийн хослол уу? Нэгдмэл асуудлын тухай авч үзэх гэж байгаа юу, салаалсан асуудлуудыг авч үзэх үү? Онолын талаас олон ургальч үзэл байдаг уу, эсвэл сүүлийн үед шинэ онол, урсгал гарч ирсэн үү?
4. Суралцагчдийн талаарх асуудлууд. Оюутнуудын одоогийн амьдралын нөхцөл ямар вэ(ажил эрхэлдэг эсэх, гэр бүлийн гишүүний үүрэг хүлээдэг эсэх, мэргэжлийн тусгайлсан зорилготой эсэх)? Оюутны энэ сэдэвтэй холбоотой өмнөх мэдлэг, туршлага нь ямар вэ? Хичээлтэй холбоотой тэдний зорилго, хүлээлт нь юу вэ? Тэд суралцах ямар арга барилд дуртай вэ?
5. Багштай холбоотой асуудлууд. Багшлах болон суралцах талаар багшийн итгэл үнэмшил юу вэ? Сэдвийн талаар ямар мэдлэгтэй вэ? Заах аргын талаар ямар давуу болон сүл талтай вэ? гэх мэт асуудлууд юм.

Нөхцөл байдлын хүчин зүйлүүд нь хичээлийн дизайнчлал хийж буй багш нарт тодорхой зааглал, хязгаарлалтыг гаргаж өгдөг. Хэрэв хичээл нь дараагийн нилээн өндөр түвшний хичээлийн үндэс болох хичээл бол тэдгээр өндөр түвшний хичээлийг зааж буй багш нарын шаардлагыг харгалзаж үзэх хэрэгтэй болно. Мөн хичээлийг судлаж буй оюутнууд хичээлийн сэдэвт тийм ч сонирхолтой биш байгаа бол хичээлийн дизайнчлалд үүнийг тооцон сэдэлжүүлэх арга, хэлбэрүүдийг ашиглах нь зүйтэй. Нөхцөл байдлын хүчин зүйлүүдийг авч үзсэний дараа суралцахуйн зорилго, зорилтуудыг тодорхойлох шаардлагатай.

2-р алхам. Суралцахуйн зорилго, зорилтыг тодорхойлох.

Нөхцөл байдлын талаарх мэдээлэл цуглуулж анализ хийсний дараа оюутнууд хичээлээс юу суралцах вэ гэдэг асуулт гарч ирнэ. Агуулгад төвлөрсөн уламжлалт аргын хувьд багш “оюутнууд Х, Y, Z сэдвүүдийг ойлгоно” гэж хэлж болно. Хэдийгээр энэ нь хялбархан боловч ерөнхийдөө Блумын таксономын ойлгох, сэргээн санах түвшинд харгалзах сургалтын хэлбэр лүү хэлбийдэг бөгөөд багш өөртөө “хичээлийг судалснаас хойш 2-3 жилийн дараа оюутанд ямар нөлөө үзүүлсээр байх вэ? Энэ хичээлийг судласан оюутан болон судлаагүй оюутны хооронд ямар ялгаа байгаа вэ?” гэдэг асуултыг тавьдаггүй. Ийм төрлийн асуултын хариулт нь шүүмжит сэтгэлгээ, хичээлээр олж авсан мэдлэгээ бүтээлчээр хэрхэн ашиглах, бодит амьдралын асуудлуудыг шийдэж сурах, оюутнуудын өөрийн болон бусдын тухай бодлыг өөрчлөх, насан туршын суралцах үйл ажиллагаанд анхаарал хандуулах хэвшил гэх мэт зүйлд анхаарахад хүргэдэг.

Ди Финк (Fink, 2003) амжилттай суралцах талаар 6 хэсэг бүхий таксономи боловсруулсан. Уг таксономийг дараах зураг харуулав.



Зураг 2

Энэ таксономийн нэг чухал онцлог нь бүх төрлийн сургалт болон суралцах үйл ажиллагаа нь идэвхтэй байх явдал юм. Өөрөөр хэлбэл нэг төрлийн сургалт болон суралцах үйл ажиллагаа нь нөгөө төрлийн суралцах/сургах ү.а-г дэмжиж байна гэсэн үг. Жишээ нь суурь мэдлэг нь “шүүмжлэлт сэтгэлгээ”-г идэвхжүүлэх” ба “үзэл, онолуудыг хооронд нь холбох”-ыг мөн дэмжин “өөрийнхөө тухай мэдэх” –ийг ч бас урамшуулсан байх ёстой. Эдгээр хичээлийн дизайнчлалын интеграцчилсан процессыг бүрдүүлнэ.

Тухайн хичээлийн зорилгод эдгээр зургаан зүйлсийг тусгасан эсэхийг тогтоохын тулд түлхүүр асуултуудыг асуух шаардлагатай. Ийм төрлийн асуултын жишээг дор өгөв.

1. **Суурь мэдлэгийг зорилго болгосон эсэхтэй холбоотой асуултууд.** Хичээлийг ойлгож, тогтооход мэдэхэд баримт, нэршил, томъёо, онол, зарчим, холбоо хамаарал гэх мэт ямар гол мэдээллүүд шаардлагатай вэ? Энэ хичээлд ямар гол санаа, харах өнцгүүд чухал ач холбогдолтой вэ?

2. **Хэрэглээг зорилго болгосон эсэхтэй холбоотой асуултууд.** Оюутнууд хичээлийг амжилттай сурахад шүүмжит, бүтээлч, практик гэх мэт сэтгэлгээний ямар хэлбэрүүд чухал ач холбогдолтой вэ? Ямар ур чадварууд шаардах вэ? Оюутнууд цогц төсөлт ажлыг гүйцэтгэхэд суралцах эсэх?

3. Интеграцчиллыг зорилго болгосон эсэхтэй холбоотой асуултууд. Энэ хичээлийг судлах явцад оюутнууд ямар хэлбэрийг холбоо хамаарлыг онцолж, мэдэх ёстой вэ? Бусад хичээлийн ямар мэдээлэл, үзэл онол, чиг хандлагатай холбох ёстой вэ? Хичээл дэхь материалууд нь оюутны хувийн амьдрал, ажил, нийгмийн амьдралтай хэрхэн холбогдох вэ?

4. Хүнтэй холбоотой асуудлуудыг зорилго болгосон эсэхтэй холбоотой асуултууд.

Оюутнууд өөрсдийн тухай юу сурсан байх вэ? Тэд бусдын талаар болон бусадтай хамтран ажиллах талаар юу сурах вэ?

5. Бусдад санаа тавих зорилго болгосон эсэхтэй холбоотой асуултууд.

Оюутнууд ямар өөрчлөлт, үнэт зүйлийг эзэмших вэ? Мэдрэмжийн талаар? Өөрийгөө зориулж, дайчлах талаар?

6. Хэрхэн суралцахад суралцахыг зорилго болгосон эсэхтэй холбоотой асуултууд.

Оюутнууд ийм төрлийн хичээлд шилдэг, сайн оюутан байхын тулд юунд суралцах вэ? Энэ тусгай сэдвийн талаар хэрхэн суралцах вэ? Хэрхэн өөрийгөө чиглүүлж, удирдсан суралцагч болох вэ (үүний тулд суралцах хувийн төлөвлөгөө боловсруулах)?

3-р алхам. Хариу дүгнэлт ба үнэлгээний процедур

Агуулгад төвлөрсөн хичээлийн хувьд явцын хоёр шалгалт болон эцсийн шалгалт авч оюутан суралцсан эсэхийг үнэлж, дүгнэхэд хангалттай гэж үздэг. Энэхүү “шалгах төрлийн үнэлгээ” нь оюутанд дүн тавихад нь багшид тусладаг. Суралцахууд төвлөрсөн хичээлийн хувьд хичээлийн дизайнчлалын энэ хэсэгт илүү зүйл хийхийг шаарддаг. Энэ тохиолдолд “сургах төрлийн үнэлгээ” гэж нэрлэгдэх эргэн өгөх дүгнэлт болон үнэлгээний цогц арга хэмжээний тухай авч үзэх шаардлагатай болдог. Энэхүү процесс, процедур нь оюутны сурлагыг дээд зэргээр дээшлүүлэх зорилготой байдаг. Дараах зурагт сургах төрлийн үнэлгээ болон шалгах хэлбэрийн үнэлгээний ялгааг харуулав.

Урагш харсан үнэлгээ нь өгсөн асуудал, бодлого, шийдвэрийг бодит амьдралтай холбосон дасгал, асуулт, бодлого хамт авч явдаг. Ийм төрлийн асуулт, даалгавар боловсруулахын тулд багш хичээл дууссаны дараах үеийг урьдчилан харж “ямар нөхцөлд оюутанд энэ мэдлэг хэрэгтэй болох эсвэл үүнийг хэрэглэх боломжтой байх вэ?” гэдэг асуултыг өөртөө тавина. Ийм асуултанд хариулах нь багшид бодлого, даалгаварыг бодит амьдралтай уялдуулан зохиоход туслана. Бодлого, даалгавар нь нээлттэй байж, анхнаасаа бүрэн бүтэцчилэгдсэн биш байх нь зүйтэй.

Жишээ. Дэлхийн газарзүйн хичээлийн зүүн өмнөд Азийн тухай хэсгээр урагш болон хойш харсан үнэлгээг харьцуулая. Хойш харсан үнэлгээ нь тухайн бүс дэх тодорхой улсын хүн ам, байгалийн баялагийн талаар асуулт асууж болно. Урагш харсан үнэлгээний хувьд оюутнуудаас тухайн мужид үйл ажиллагаа явуулахаар бэлтгэж байгаа компанид ажиллаж байгаа гэж төсөөлөн компани тус бүс мужаас улс төрийн хувьд тогтвортой, худалдан авах чадвар сайтай, эдийн засгийн өсөлт сайн улсыг тодорхойлох зорилт тавьж байгаа гэж төсөөлөхийг хүсэж болно. Ийм төрлийн асуулт нь оюутнаас юу сурсанаа ашиглахыг шаардана.

Оюутныг үнэлэхэд тавигдах шалгуур болон стандартыг оюутанд тодорхой тайлбарлаж өгөх нь чухал байдаг. “Энэ чиглэл дэх ажлын өндөр чанар гэж юу болох талаар ерөнхий шалгуур юу” болохыг багш тодорхойлж оюутнуудад тайлбарлах нь чухал. Эдгээр нь үнэлгээний шинжүүр болно. Шалгуур болгоны хувьд хүлээж авч болохуйц, сайн, онцгой ажлыг тодорхойлох стандарт тогтоох шаардлагатай.

Багш оюутныг өөртөө үнэлгээ хийх боломж үүсгэх нь бас чухал ач холбогдолтой. Хожим бодит амьдрал дээр тэд өөрсдийн гүйцэтгэлийг үнэлэх шаардлага гарах учир оюутан байх хугацаандаа энэ ажлыг эхлүүлж байх нь чухал юм. Анх энэ ажлыг бүлгээр хийх нь зүйтэй бөгөөд хэсэг дадлага хийсний дараа хоорондоо ярилцан өөрийн ажлыг үнэлэх тохиромжтой шалгуур боловсруулах хэрэгтэй.

Оюутнуудыг хэрхэн сайн сурахад сургаж буй тул багш нар оюутнуудад “FIDeLity” буюу “үнэнч” шинж чанартай хариу дүгнэлтүүдийг өгөх хэрэгтэй:

- **Frequent** –Тогтмол: Хариу дүгнэлтийг аль болох давтамжтай, өдөр бүр биш юм гэхэд дор хаяж долоо хоногт нэг удаа.
- **Immediate** –Шуурхай: Хариу дүгнэлтийг оюутнуудад аль болох шуурхай өгөх.
- **Discriminating** –Ялгавартай: Мүү, хүлээж авахуйц, онцгой ажлуудын ялгааг тодорхой зааж өгөх.
- **Loving** –Хүндэтгэлтэй: Хариу дүгнэлтийг мэдрэмжтэй бөгөөд хүчтэйгээр өгөх.

Дээрх шинж чанарын хэрхэн тусгах процессийг товчлон харуулав:

1. **Урагш харсан үнэлгээ.** Оюутнууд сурсан зүйлээ ашиглах нөхцөл, тохиолдыг томъёол. Дараа нь тэдгээр тохиолдлоо асуулт, даалгавар, бодлогоор илэрхийл.
2. **Шалгуур ба стандарт.** Гол зорилгуудын хувьд мүү гүйцэтгэлийг онцгой сайн гүйцэтгэлээс ялгасан, дор хаяж хоёр шалгуур зохио. Шалгуур болгоны хувьд хоёроос гурван түвшний стандарт зохиож бич.
3. **Өөрийн үнэлгээ.** Оюутнууд өөрсдийн гүйцэтгэлийг үнэлэх боломж үүсгэ.
4. **“FIDeLity” хариу дүгнэлт.** Тогтмол, шуурхай, ялгавартай(тодорхой шалгуур, стандартад үндэслэсэн), хүндэтгэлтэй хариу дүгнэлт өгөх процедур боловсруул.

4-р алхам. Багшлах/суралцах үйл ажиллагаа

Өмнөх үеийн дээд боловсролын ном, бүтээлүүд багшид анхаарал хандуулж, агуулгыг оюутнуудад хэрхэн хүргэх талаар голлон авч үздэг болсон. Лекц болон хэлэлцүүлэгт анхаарал хандуулж суралцах үйл ажиллагаа нь идэвхгүй байж суралцагчид мэдээллийг дээрээс хүлээн авч байгаа гэж үздэг байсан. Гэхдээ сүүлийн үеийн олон судалгаануудаас харвал идэвхгүй бус харин идэвхтэй хэлбэрээр суралцвал илүү ихийг сурч, удаан хугацаанд тогтоодог ажээ.

Бонвелл, Ейсон нар (Bonwell, 1991) идэвхтэй суралцах үйл ажиллагааг “оюутнуудыг юм хийхэд оролцуулах, өөрсдийн хийж байгаа зүйлийн талаар бодох” гэж тодорхойсон. “Юм хийх” гэдэг нь маргаан, симуляц, дизайнчлал хийх, бүлгээр эсвэл дангаар асуудлыг шийдвэрлэх, кейс судалгаа хийх зэргийг багтаана. Бодох гэдэгт өөрсдийн сурсан зүйл эсвэл сурах үйл ажиллагааны утга учирын талаар тунгаах үйл ажиллагааг багтаана.

Чанартай сургалтыг дэмжихийн тулд багшлах/суралцах үйл ажиллагааны талаар нэгдмэл үзэл бодол шаардлагатай. Идэвхтэй сургалтын талаар зөвлөхүүдийн бэлтгэсэн материалтай танилцана уу (Амарзаяа & Виннеоу, 2016).

5-р алхам. Интеграцилал

Хичээлийн дизайнчлал нь хангалттай сайн интеграцчилахын тулд эхний дөрвөн алхмыг зөв, чанартай хийсэн эсэхийг сайн нягтлах хэрэгтэй. Дээрх алхмууд болон тэдгээрийн харилцан хамаарлыг шалгасан асуултуудыг асууж үзэх шаардлагатай.:

“Нөхцөл байдлын хүчин зүйл” - тэй холбоотой асуултууд:

- Нөхцөл байдлын хүчин зүйлүүдийг сургалтын зорилго, хариу дүгнэлт ба үнэлгээ, суралцах үйл ажиллагаанд хэрхэн сайн тусгасан бэ?
- асуудал үүсгэхүйц зөрчилтэй зүйл байна уу?
- багшийн үнэт зүйл, оюутны шинж чанар, тусгай болон ерөнхий сэдэв*асуудал, сэдвийн мөн чанарын хооронд хамааралгүй зүйл байна уу?

“Суралцахуйн зорилго, зорилт” - той холбоотой асуултууд:

- Үнэлгээний үйл явц суралцахуйн зорилго, зорилтыг бүгдийг хамарч чадсан уу?
- Төлөвлөсөн хариу дүгнэлт нь суралцахуйн зорилго, зорилгын дагуу оюутанд түүний ахиц дэвшлийн талаар мэдээлэл өгч чадаж байгаа юу?
- өөрсдийн гүйцэтгэлийг хэрхэн үнэлэх талаар суралцахад оюутнуудад туслалцаа үзүүлсэн үү?

“Суралцахуйн зорилго” ба “Багшлах/суралцах үйл ажиллагаа” - тай холбоотой асуултууд:

- Суралцах үйл ажиллагаа суралцахуйн бүх зорилгыг дэмжиж чадаж байгаа юу?
- Зарим үйл ажиллагаанууд “илүүдэл” үү (аль зорилготой хамааралгүй юу)?

“Багшлах/суралцах үйл ажиллагаа” ба “Хариу дүгнэлт ба үнэлгээ” - тэй холбоотой асуултууд:

- Хариу дүгнэлтүүдийн цуврал нь гүйцэтгэлийг үнэлэх шалгуур болон стандартын талаар ойлгоход оюутнуудад туслаж чадаж байна үү?
- Суралцах үйл ажиллагаа болон хариу дүгнэлтүүд нь тэднийг эцсийн үнэлгээнд бэлдэж чадаж байна үү?

Дараагийн алхам нь суралцах үйл ажиллагааны динамик дарааллуудыг үүсгэх буюу багшлах стратегиудыг бий болгох юм. Энэ талаар (Fink, 2003)-с дэлгэрэнгүй танилцаарай.

Ашигласан ном, зохиол

Anderson, L. W. (2001). *A Taxonomy for Learning, Teaching, and Assessing: A Revision of Bloom's Taxonomy of Educational Objectives*. . Boston: Allyn & Bacon, MA (Pearson Education Group).

Bonwell, C. &. (1991). *Active Learning: Creating Excitement in the Classroom, ASHE-ERIC Higher Education Report*. Washington DC: George Washington University.

Fink, D. (2003). *Creating Significant Learning Experiences: An Integrated Approach to Designing College Courses*. San Francisco: Jossey-Bass.

Амарзаяа & Виннеоу. (2016). *ШИЛДЭГ ТУРШЛАГУУД ДЭЭР ТУЛГУУРЛАН БАГШЛАХ БОЛОН СУРАЛЦАХ ҮЙЛИЙГ ЧАНАРЖУУЛАХ НЬ, АХБ-НЫ ДЭЭД БОЛОВСРОЛЫН ШИНЭЧЛЭЛИЙН ТӨСӨЛ*. Улаанбаатар.